



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 8/13

Жавхлант

**Э.Уранбайгалийг ажилд
томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 47 дугаар зүйлийн 47.1, Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын 10 дугаар хавсралт, 2024 оны 02 дугаар сарын 28-ны 82 дугаар тогтоол "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам"-ын хавсралтын 2.1, 2.2 заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын ИТХ, Соёлын төв, сангууд хариуцсан Нягтлан бодогчоор Эрдэнэбаатарын Уранбайгалийг 2025 оны 04 дүгээр сарын 04-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Э.Уранбайгалийн цалинг ТҮМ-7 зэрэглэлээр 1 559 000 (нэг сая таван зуун тавин есөн мянга) төгрөгөөр тогтоож төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 4%-иар орон нутгийн нэмэгдлийг 40%-иар тус тус тооцож олгохыг Нягтлан бодогч (Э.Уранбайгаль)-д үүрэг болгосугай.

3. Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Т.Эрдэнэцэцэг- Санхүү албаны дарга

Гишүүдэд: З.Дэлгэрмаа - Нягтлан бодогч

Г.Батсайхан - Нярав

4. Хариуцсан ажилдаа идэвхи санаачилга гарган, хууль тогтоомжийн хүрээнд ажиллахыг Нягтлан бодогч (Э.Уранбайгаль)-д даалгасугай.

ДАРГА

Р.ОЮУНЧИМЭГ

